



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 286 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба (хуучнаар Замын цагдаагийн газар)-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг худалдах нээлттэй дуудлагын худалдаанд нэг ч оролцогч ирээгүй тул дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2. Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг худалдах нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тооцож 13,860,800,000.00 (арван гурван тэрбум найман зуун жаран сая найман зуун мянган) төгрөг дээр үнэлгээний ажлын зардал 7,000,000.0 (долоон сая) төгрөгийг нэмж 13,867,800,000.00 (арван гурван тэрбум найман зуун жаран долоон сая найман зуун мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

3. Дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 10 хувь буюу 1,386,780,000.00 (нэг тэрбум гурван зуун наян зургаан сая долоон зуун наян мянган) төгрөгөөр, үнэ өсгөх доод шатлалыг 10,000,000.00 (арван сая) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, нийтэд зарлахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль, захиргааны актын дагуу зохион байгуулахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны
өдрийн 121 дүгээр тогтоолын хавсралт



**ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
5 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ ДООД ҮНЭ**

Д/д	Барилга байгууламжийн нэр	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 59 дүгээр тогтоолоор тогтоосон анхны доод үнэ (төгрөг)	Бууруулсан үнэ		Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
			Хувиар	Төгрөгөөр	
1	Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламж	17,326,000,000.00	20	3,465,200,000.00	13,860,800,000.00